

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТЫН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд болон түүний холбогдох ажилтанд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хууль, журмын талаарх сургалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУРГАЛТ, СУРГАЛТЫН БҮТЭЦ

2.1 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, менежер, байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн нь холбогдох эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

2.2 Цахим сургалтыг Хороотой сургалт зохион байгуулах гэрээ байгуулсан хуулийн этгээд зохион байгуулна.

2.3 Энэ журмын 2.1-д заасан этгээд цахим сургалтын системд байршуулсан хичээлийг хэдийд ч хандаж судлах, шалгалт сорилго /тест/ өгөх боломжтой байх ба сургалтын үргэлжлэх хугацаа 72 цагаас илүүгүй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Сургалт зохион байгуулагчид дараах шаардлага хангасан байна:

3.1.1. сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавх бүхий сургагч багштай байх;

3.1.2. сургалт зохион байгуулах цахим систем, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх;

3.1.3. сургалтын үйл ажиллагаа эрхлэх журамтай байх;

3.1.4. батлагдсан орон тоо бүхий сургалтын нэгж, эсхүл сургалтын асуудал хариуцсан орон тооны ажилтантай байх;

3.1.5. сургалт зохион байгуулах цахим систем нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан харьяалах бүртгэлийн байгууллагаас сургалтад тэнцсэн оролцогчийн мэдээллийг шалгах боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байх.

3.2. Сургалтын төлбөрийг сургалт зохион байгуулагч Хороотой байгуулах сургалтын гэрээгээр тодорхойлно.

3.3. Сургалт зохион байгуулагч нь сургалтын хөтөлбөрийн төслийг Хороонд хүргүүлж, батлуулна.

3.4. Сургалт зохион байгуулагч нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан этгээдэд 1 жилийн дотор үнэ төлбөргүй зохион байгуулна.

---oOo---

СУРГАЛТЫН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

№	Сургагч байгууллага	Овог	Нэр	Албан тушаал	Регистр	Цахим хаяг	Утасны дугаар